



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 8-р сарын 06 өдөр

Дугаар 4.178

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүрэгт Тохижилт үйлчилгээний компани байгуулах, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэд Тохижилт үйлчилгээний компанийг "Шонхор" ББХК-ний барилга байгууламжийг түшиглэн, зам талбайн цэвэрлэгээ, хот нийтийн аж ахуй, ногоон байгууламж, авто аж ахуйн хэсгүүдтэйгээр 1993 оны 08 дугаар сарын 29-ноос эхлэн зохион байгуулан ажиллуулсугай.

2. "Шонхор" ББХК-аас худалдан авах Хавсралт I-д заасан 940,3 мянган төрөгийн үндсэн хөрөнгийн үнийг Чингэлтэй дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө давсан хувиас гаргахыг Чингэлтэй дүүргийн Засаг дарга /н.Зул/-д зөвшөөрсүгэй.

3. Шинээр байгуулагдаж буй компанийн дүрмийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

- | | |
|----------------|--|
| Комиссын дарга | -БХТГ-ын орлогч дарга Отгонсүрэн |
| Орлогч дарга | -Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч Энхболд |
| Гишүүнэд | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Долоонжин |
| | -Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн зохион байгуулагч Жаргал |
| | -Сүхбаатар дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн захирал Хасбазар |
| | -"Шонхор" ББХК-ийн захирал Тогтмол |
| | -Тусгай үйлчилгээний авто комбинатын захирал Тогтохбаяр |

4. Шинээр байгуулагдаж буй тохижилт үйлчилгээний компанид Сүхбаатар дүүргийн ТҮК-аас Хавсралт № 2-т дурьдсан 12891,1 мян-

2.

ган төгрөгийн, Тусгай үйлчилгээний авто комбинатаас Хавсралт №3-рт дурьдсан 305,4 мянган төгрөгийн машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, үнцсэн хөрөнгийг, ноогдох эргэлтийн орлон сэргээн босголт их засварын хөрөнгийн хамт балансаас балансад шилжүүлэхийг дээрхи аж ахуйн нэгжүүдийн дарга /н.Хасбазар, Тогтохбаяр/-нарт даалгасугай.

5.Компаний дүрэм, дүрмийн санг баталж, захирлыг нь томилохыг Чингэлтэй дүүргийн Засаг дарга /н.Зул/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

Ц.БААСАНЖАВ

Засаг захиргааны хэлтэс

Боловсруулсан

4% м Мөнгөнцэцэг

-нийлсэн